

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАЖ БАЙГАА БОЛОВЧ
ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ
САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “”ЦДҮС” ТӨХК-ИЙН ТӨВИЙН БҮСИЙН САЛБАРЫН 2019,
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДАА-2021/71-ШТА-ГА



Дархан-Уул аймаг
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Аудитын менежер Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Сувдмаа

Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. САЛБАРЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАЖ БАЙНА.	7
1.1. Шуурхай ажиллагаа, үйлдвэрлэлтэй холбоотой дэвшүүлсэн 4 зорилт бүрэн хэрэгжээгүй байна.	7
1.1.1. Зарим зорилтод хүрэх ажлын төлөвлөгөөг боловсруулаагүй байна.	7
1.1.2. Зардал хэтэрснээс шалтгаалж зорилтот түвшин бүрэн биелээгүй байна.	7
1.2.1. Хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөг судалгаа шинжилгээнд үндэслэн боловсруулаагүй байна.	10
1.2.2. Дотоод хяналтын ажилтны өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	10
БҮЛЭГ 2. ТӨЛӨВЛӨСӨН ЗАРДЛЫГ ХЭТРҮҮЛЭН ЗАРЦУУЛЖ БАЙНА.	12
2.1. Салбарын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, орлогын төлөвлөгөө 93.7 хувиар биелсэн байна.	12
2.1.1. ААНБ-аас цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалга, тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөжээ.	12
2.1.2. ЭХЗХ-ны тогтоолыг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар сар бүр тогтмол тарифаар орлогоо тооцож байна.	13
2.2. Төлөвлөсөн хөрөнгийг хэтрүүлэн зарцуулж байна.	14
2.2.1. Зарим зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.	14
2.2.2. Салбарын төлөвлөсөн зардлыг бууруулж баталснаас нийт зардал 3.9-4.3 хувиар хэтэрсэн байна.	14
БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	18
3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.	18
3.1.1. Гүйцэтгэх захирлын тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг 2019 онд 14.3 хувь, 2020 онд 34.6 хувиар тус тус бууруулан баталжээ.	18
3.1.2. Худалдан авах үйл ажиллагааны хууль журмын хэрэгжилт хангалтгүй байна.	18
3.2. Өмч хамгаалах зөвлөлийн журмыг шинэчлэн боловсруулаагүйгээс хөрөнгөд тавих зарим хяналтын ажил орхигдож байна.	21
3.2.1. Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө эргэлтийн хөрөнгийн 17.8 хувийг эзэлж байна.	21
3.2.2. Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулаагүйгээс зарим хяналтын ажил орхигдож байна.	22
ДҮГНЭЛТ:	24
ЗӨВЛӨМЖ:	25

Товчилсон үгийн тайлбар

ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
АДБООУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДДЦС	Дарханы дулааны цахилгаан станц
ОХУ	Оросын Холбооны Улс
ДСЦТС	Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ТХМС	Тоолуур хяналт мэдээллийн систем
МП	Микро процессор
ОТУ	Оператив тэжээлийн үүсгүүр
РХА	Реле хамгаалалт, автоматик
РХАХТ	Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилт
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ТЗБАХ	Техник, зохион байгуулалтын арга хэмжээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ОБГ	Онцгой байдлын газар
УЗН	Улаан загалмайн нийгэмлэг
ЦЭХС	Цахилгаан эрчим хүчний салбар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХК	Хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХТ	Хүчдэлийн трансформатор
ОПУ	Общелодстанионный пункт управления
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБС	Төвийн бүсийн салбар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
АШҮА	Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Зорилтот түвшний биелэлтийг харьцуулсан судалгаа /хувиар/	8
Хүснэгт 2	Ажилтнуудын мэргэшил, боловсрол, мэргэжлийн зэргийн судалгаа /тоогоор/	9
Хүснэгт 3	Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/	12
Хүснэгт 4	Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 5	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 6	Урсгал засварын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 7	Нийгмийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 8	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлын төсөл, батлагдсан төлөвлөгөө /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 9	Агуулахад байгаа эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөн /сая төгрөгөөр/	21

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ажилласан жилийн судалгаа /хувиар/	9
Дүрслэл 2	Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төрөл /сая төгрөгөөр/	19
Дүрслэл 3	Бараа материалын үлдэгдлийн насжилт /сая төгрөгөөр/	22

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2021 оны А/28 дугаар тушаал Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу өөрсдийн санаачилгаар “ЦДҮС ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын 2019, 2020 оны үйл ажиллагаа, үр дүн”-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилт	“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын 2019, 2020 оны үйл ажиллагаа, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Салбарын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх; ➤ Салбарын орлогыг бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй заруулсан эсэх; ➤ Худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг “ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын 2019, 2020 оны үйл ажиллагааг хамруулан дэд зорилтуудын хүрээнд гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, худалдан авалт, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Батсүрэн, Х.Сувдмаа, аудитор Б.Алтанзул, Ч.Гантулга, Г.Батмягмар, Н.Отгонцэцэг нар хамтран төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 6 дугаар сарын 30 хүртэл гүйцэтгэж, тайланг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор тушаалаар баталгаажуулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.
Хүндрэл бэрхшээл	

Ерөнхий мэдээлэл

“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар нь 1965 онд Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газар нэртэйгээр анх байгуулагдаж, 2001 онд “Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК-ийн Дархан-Сэлэнгийн салбар нэртэй болж өөрчлөгджээ. 2012 онд “ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар нэртэйгээр бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Төвийн бүсийн салбар нь “ДЦС-4”, “ДДЦС” ТӨХК-уудын үйлдвэрлэсэн болон ОХУ-аас импортолж буй эрчим хүчийг Дархан-Уул, Сэлэнгэ, Төвийн аймгийн 28 сум суурин газрыг хамарсан хэрэглэгчдэд ЦЭХ түгээж, “ДСЦТС” ХК, Төмөр замын 1 дүгээр анги, “Эрчим хүч” ХК зэрэг түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ОХУ-руу экспортлон дамжуулж байна. Мөн 0.4-220кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, урсгалт түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ үзүүлдэг байна. Салбарын эзэмшилд 220 кВ-ын нийт 310.52 км, 110 кВ-ын нийт 699.65 км шугам, 18 дэд станцын ашиглалтыг хариуцдаг.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ЦЭХ импортлох, экспортлох, цахилгаан дамжуулах, цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засварын ажил, туршилт тохируулга хийх тусгай зөвшөөрлийн хүрээнд “ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны А/12 тоот тушаалаар 5 алба 207 ажилтантай ажиллаж байна.

Тус салбар 2019 онд 549.6 сая.кВт.цаг ЦЭХ худалдан авч, 518.1 сая.кВт.цаг ЦЭХ худалдсан бол 2020 онд 572.4 сая.кВт.цаг ЦЭХ худалдан авч, 538.5 сая.кВт.цаг ЦЭХ худалдаж өмнөх оноос худалдан авалт 4.1 хувиар, худалдсан ЦЭХ 3.9 хувиар тус тус өссөн байна.

Тус салбар 2019 онд 6,800.6 сая төгрөгийн орлого олж, орлого 5.9 хувиар тасарсан бол 2020 онд 7,348.6 сая төгрөгийн орлого олж, орлого 0.3 хувиар давсан байна. Мөн 2019 онд 643.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөснөөс 707.8 сая төгрөгөөр, 2020 онд 657.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөснөөс 310.3 сая төгрөгөөр алдагдал тус тус өсжээ.

Нийт зардлыг 2019 онд 7,165.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэл 103.9 хувь, 2020 онд 7,674.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэл 104.3 хувьтай гарч, сүүлийн 2 жилд төлөвлөсөн зардал хэтэрч, борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 2019 онд 1.095 төгрөг байсан бол 2020 онд 1.09 төгрөг болж өмнөх оноос 0.005 төгрөгөөр, төлөвлөснөөс 0.04-0.1 төгрөгөөр тус тус өссөн байна.

БҮЛЭГ 1. САЛБАРЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАЖ БАЙНА.

1.1. Шуурхай ажиллагаа, үйлдвэрлэлтэй холбоотой дэвшүүлсэн 4 зорилт бүрэн хэрэгжээгүй байна.

1.1.1. Зарим зорилтод хүрэх ажлын төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

Салбарын “Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан ЦЭХ-ийг үр ашигтай дамжуулна” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 2019 онд 18, 2020 онд 19 зорилт дэвшүүлжээ. Дэвшүүлсэн зорилт, түүнд хүрэх ажлын төлөвлөгөөний уялдааг үзэхэд дараах шуурхай ажиллагаа, үйлдвэрлэлтэй холбоотой 4 зорилтод хүрэх ажлын төлөвлөгөөг боловсруулаагүй байна. Үүнд:

2019 оны зорилт:

- Шуурхай ажиллагаанд компьютерын алсын удирдлагын систем нэвтрүүлэх

2020 оны зорилт:

- ТХМС-ийг салбарын хүрээнд ажиллагаанд оруулж зүгшрүүлэх
- МП-ын хамгаалалтын тоог нэмэгдүүлж найдвартай ажиллагааны түвшнийг дээшлүүлнэ.
- Үйлдвэр дэд станцын тогтмол ОТҮ-г шинэчилж РХА-ын найдвартай ажиллагааны түвшнийг нэмэгдүүлнэ зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулаагүйгээс дээрх зорилтууд бүрэн биелээгүй.

Мөн эдийн засаг, санхүүгийн чиглэлээр дэвшүүлсэн 6 зорилтод хүрэх ажлын төлөвлөгөөг “салбарын зорилтот түвшин биелүүлэх” гэсэн нь зарим зорилттой уялдахгүй байна.

Иймд байгууллагын зорилт, ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа харилцан уялдаатай, биелэгдэхүйц байхаас гадна цаг хугацаа, боловсон хүчин, техник тоног төхөөрөмжийн нөөц, санхүүгийн эх үүсвэр, судалгаанд тулгуурлах шаардлагатай байна.

Зорилтод хүрэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2019 оны 77 ажлаас 70.1 хувийг, 2020 оны 62 ажлаас 51.6 хувийг аудитын түүвэрт хамруулж, салбарын ажлын тайлан, сар бүрийн ажлын гүйцэтгэлтэй харьцуулав. Аудитаар 2019 онд 4 ажил хэрэгжээгүйгээс гүйцэтгэл 92.5 хувь, 2020 онд 3 ажил бүрэн хийгдээгүйгээс гүйцэтгэл 90.3 хувьтай гарлаа.

Зорилтот түвшнийг биелүүлэх ажил сүүлийн 2 жил зардлын төлөвлөгөөнөөс шалтгаалж хэрэгжээгүй бол агуулахад галын хор тавьж, дохиолол суурилуулах, Үйлдвэр дэд станцын лоткины таг солих, Шарын гол дэд станцын хашааны суурь цутгах зэрэг ажил хөрөнгийн эх үүсвэртэй холбоотойгоор, харин явган аялал, тэмцээн, РХАХТ-ын ажилтнуудын зөвлөгөөн “КОВИД-19” цар тахлын улмаас тус тус хийгдээгүй байна.

1.1.2. Зардал хэтэрснээс шалтгаалж зорилтот түвшин бүрэн биелээгүй байна.

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар салбарын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг жил бүр 13 үзүүлэлтээр баталж, салбарт ирүүлсэн байна.

Салбарын дамжуулах ЦЭХ 2020 оны гүйцэтгэлээр 572.4 сая.кВт.цагт хүрч, төлөвлөгөөнөөс 9.2 сая.кВт.цагаар, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 22.8 сая.кВт.цагаар тус тус өссөн байна. Үүнтэй холбоотойгоор 2020 оны дамжуулсан ЦЭХ 538.5 сая.кВт.цагт хүрч, төлөвлөгөөнөөс 8.0 сая.кВт.цагаар, урьд оны гүйцэтгэлээс 20.4 22.8 сая.кВт.цагаар тус тус өсжээ. Зорилтот түвшний биелэлтийн хувийг хүснэгтээр зэрэгцүүлж харуулав.

Хүснэгт №1

Зорилтот түвшний биелэлтийг харьцуулсан судалгаа /хувиар/

№	Үзүүлэлт	Зорилтот түвшний биелэлтийн хувь		Зөрүү
		2019 он	2020 он	
1	Дамжуулах ЦЭХ	105.7	101.6	(4.0)
2	Дамжуулалтын алдагдал хувиар	86.3	102.1	15.8
3	Дамжуулсан ЦЭХ	106.7	101.5	(5.2)
4	Нийт орлого	94.1	100.3	6.2
5	Нийт зардал	103.9	104.3	0.4
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(997.4)	189.4	1,186.8
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	110.4	104.0	(6.4)
8	Нийт авлага	-	-	-
9	Нийт өр төлбөр	114.3	45.7	(68.6)
10	ТЗБАХ, хөрөнгө оруулалт, их засвар	99.0	106.4	7.4
11	Нийт ажиллагсдын тоо	99.5	99.5	0.0
12	Нийт цалингийн сан	103.2	99.8	(3.4)
13	Нэг ажилтны дундаж цалин	103.7	100.3	(3.4)

Зорилтот түвшин 2019 онд 8, 2020 онд 6 үзүүлэлт биелээгээгүйгээс дараах үзүүлэлтүүд 2 жил дараалан төлөвлөснөөс хэтэрсэн байна. Үүнд:

- Нийт зардал
- Татварын өмнөх ашиг /алдагдал/
- Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал
- Нэг ажилтны дундаж цалин

2019 онд гүйцэтгэх захирлын тушаалаар цалин 2 удаа нэмэгдсэн, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэнээс элэгдлийн зардал өссөн зэргээс шалтгаалсан бол 2020 онд гүйцэтгэх захирлын тушаалаар зардлыг 10 хувиар бууруулж тодотгосон нь нийт зардал хэтрэхэд нөлөөлжээ.

Үүнээс үзэхэд дамжуулах болон дамжуулсан ЦЭХ төлөвлөсөн түвшнээс 1.5-6.7 хувиар давж үндсэн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа боловч нийт зардал хэтэрсэн, алдагдал өссөн зэрэг санхүүгийн үйл ажиллагаа компанийн гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрээс шалтгаалж байна.

1.1.3. Ажлын дадлага, туршлагатай боловсон хүчин бүрджээ.

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар салбарын орон тоог 2019 онд 207, 2020 онд горим баланс тооцоо, төсвийн инженерийн орон тоог 2 салгаж, Баясгалант дэд станцад хэрэгчдийн тоо, ажлын ачааллыг харгалзан 1 монтер нэмж, 209 орон тоо баталжээ.

Салбарын үйл ажиллагааны тайланд 2019 онд 4, 2020 онд 3 орон тоогоор дутуу ажилласан гэж тайлагнасан боловч аудитаар ажилласан орон тоог даргын тушаал, цалингийн цэстэй тулгахад 2019-2020 онд тус бүр 2 орон тоогоор дутуу ажиллажээ. Үүнд:

2019 онд гүйцэтгэлээр:

- 110 кВ-ын Хаалттай хуваарилах байгууламжид ээлжийн монтёр,
 - Бурхант дэд станцад ээлжийн техникч,
- 2020 онд гүйцэтгэлээр:
- Орхон дэд станцад ээлжийн техникч,
 - Бугант, Толгойт дэд станцын жолоочийн орон тоонд ажилтан ажиллаагүй байна.

Аудитаар инженер техникийн ажилтнуудын мэргэжил, боловсрол, ажлын туршлагыг ажлын байрны тодорхойлолтод заасан шалгууртай харьцуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сургалт, бүтээмжийн инженер Б.Байгалмаа “Цахилгааны инженер” мэргэжилтэй байх, боловсролын “Бакалавр” зэрэгтэй байх шалгуур,
- Реле хамгаалалт, программчлалын инженер Э.Амартүвшиний мэргэжил, боловсролын зэргийг гэрчлэх баримт бичиг хувийн хэрэгт байхгүй нь ажлын байрны тодорхойлолтод заасан шалгууртай тус тус нийцэхгүй байна.

Нийт ажиллагсдын 48.8 хувь нь инженер техникийн ажилтан бөгөөд 18 дэд станцад 59.9 хувь нь, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд 82.6 хувь нь ажиллаж байна.

Хүснэгт №2

Ажилтнуудын мэргэшил, боловсрол, мэргэжлийн зэргийн судалгаа /тоогоор/

Албан тушаалын ангилал	Нийт	Үүнээс							
		Мэргэшлийн зэрэг				Боловсрол		Мэргэжлийн зэрэг	
		Зөвлөх инженер	Тэргүүлэх төсөвчин	Мэргэшсэн инженер	Мэргэшсэн нягтлан бодогч	Дээд	Тусгай дунд	III ба IV	V ба VI
Удирдлага	4	1	-	2	-	4	-	-	-
Инженер техникийн ажилтан	97	1	1	2	1	91	4	-	-
Мэргэжилтэй ажилтан	104	-	-	-	-	52	21	60	31
Бага тушаалын ажилтан	2	-	-	-	-	-	-	-	-
Бүгд	207	2	1	4	1	147	25	60	31

Эх сурвалж: Салбарын 2020 оны хүний нөөцийн судалгаа

Дээрх судалгаанаас үзэхэд ажилтнуудын 71 хувь дээд боловсролтой, 12 хувь нь тусгай дунд боловсролтой байгаагаас мэргэшсэн зэрэгтэй боловсон хүчин

Дүрслэл №1

4 хувийг эзэлж байна. Мөн мэргэжилтэй ажилтнуудын 58 хувь нь III, IV зэрэгтэй, 30 хувь нь V, VI зэрэгтэй байгаа бөгөөд нийт ажилтнуудын 70 хувь нь эрчим хүчний салбарт 6-аас дээш жил ажилласан нь мэдлэг чадвар, дадлага туршлагатай боловсон хүчнээр хангагдсаныг харуулж байна.

Ажилласан жилийн судалгаа /хувиар/



1.2. Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

1.2.1. Хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөг судалгаа шинжилгээнд үндэслэн боловсруулаагүй байна.

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны А/230 тушаалаар баталсан “Үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д заасан салбарын дотоод хяналтын ажилтны үүргийг ХАБЭА-н инженерүүд гүйцэтгэж байна.

Албадын үйл ажиллагаанд 2019-2020 онд нийт 13 удаагийн хяналт шалгалт хийх төлөвлөгөө боловсруулж, салбарын даргаар батлуулжээ. Үүнд:

- ТЗБАХ, техник шинэчлэлийн ажлуудын гүйцэтгэлийн тайлан, техникийн баримт бичиг, актын бүрдэл,
- Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой баримт бичиг, инженерийн шугам сүлжээ, байгууламж, автомашин, автограж, химийн хорт бодисын агуулахууд
- Салбарын хэмжээнд хийгдсэн гэрээг бүртгэх, түүний биелэлтэд хяналт тавих, архивлах, журмын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийсэн байна.

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гал, гамшгийн аюулгүй байдлыг хангах, ажлын байрны 3-р шатны үзлэг зэрэг шалгалт хийхээр ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан, гүйцэтгэлийг ханган ажиллажээ.

Гэсэн хэдий ч өмнөх жилүүдийн хяналт шалгалтын дүн, илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнээгүй, мэдээллийн сан бүрдүүлээгүй зэрэг нь хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө судалгаа шинжилгээнд үндэслэдэггүй болохыг харуулж байна. Энэ нь гүйцэтгэх захирлын А/230 дугаар тушаалаар баталсан дотоод хяналт шалгалтын журмын 4.5.4¹-д заасантай нийцэхгүй байна.

Иймд дотоод хяналт шалгалтын талаар эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлж, судалгаа шинжилгээнд үндэслэн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулахад анхаарч ажиллах нь зүйтэй.

1.2.2. Дотоод хяналтын ажилтны өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Дотоод хяналт шалгалтын ажилтнууд салбарын үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалт хийж, 2019 онд илэрсэн 96 зөрчлөөс 87.5 хувийг, 2020 онд илэрсэн 260 зөрчлөөс 56 хувийг арилгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ. Хяналтад шалгалтын биелэлтэд 2019 оны “Гэрээг бүртгэх, түүнд хяналт тавих, дүгнэх, архивлах журмын хэрэгжилт”, 2020 оны “Их засвар, ТЗБАХ-ний ажлын гүйцэтгэлийн тайлан, техникийн бичиг баримт, актуудын бүрдүүлэлт”-д хийсэн шалгалтуудын гүйцэтгэл огт ирүүлээгүй нь нөлөөлсөн байна.

Иймд дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, дахин зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, зөрчлийг арилгаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах нь зүйтэй юм.

Ажлын байрны 3-р шатны үзлэгийг 2019 онд хөдөлмөрийн аюулгүй байдал, 2020 онд журнал, бичиг баримт хөтлөлт чиглэлээр төлөвлөгөө удирдамжийн дагуу

¹ Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх

хийж, 2019 онд 359 зөрчил илрүүлснээс 95.5 хувийг, 2020 онд 339 зөрчил илрүүлснээс 88.7 хувийг арилгуулсан байна.

Дотоод хяналтын ажилтны тайлангаас үзэхэд зарим шалгалт давхцаж байна. Тухайлбал:

- Ажлын байрны үзлэг шалгалт /ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээ/
- Албаны бичиг баримтын бүрдүүлэлт, хөтлөлт /тоног төхөөрөмж, машин механизм, техник ашиглалт/

“ЦДҮС” ТӨХК-ийн хяналт мониторингийн хэлтэс гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу салбарын 2019 оны сүүлийн хагас жил, 2020 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, шугам тоноглолын ашиглалт, техникийн бэлэн байдал, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтын мөрөөр 25 ажлыг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнажээ. Харин дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Автогражууд, цайны газар, сантехникийн өрөөнд ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх, автомашин, сантехникийн засварын ажилбар тус бүрээр ажил гүйцэтгэх үеийн эрсдэлийн үнэлгээ, тухайлсан зааварчилгаа боловсруулах,
- Дулаан хаан дэд станцад галын гарцын схемийг баталгаажуулах,
- 2017-2018 оны НДШ төлөлтийн тайланд залруулгын тайлан хийх гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар ХАБЭА-ын инженерүүдийн хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж, ажлын тайлангаас харахад ажлын байрны тодорхойлолтод заасан хяналтын чиг үүргээ зохих хэмжээнд сайн гүйцэтгэсэн байгаа ч дотоод хяналт шалгалтын ажлын баримт материалыг архивын нэгж болгох ажил хангалтгүй байна. Иймд дотоод хяналт шалгалтын ажлын үр дүнг сайжруулах, ажлын баримт материалыг архивын нэгж болгоход удирдлагын зүгээс онцгой анхаарах шаардлагатай байна.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, өдөр тутмын, гэнэтийн үзлэгээр илэрсэн зөрчлийг холбогдох хэлтэс, цехэд хугацаатай албан даалгавар өгч, зарим хэрэгжилтийг нь фото зургаар баримтжуулсан байв. Мөн 2019 онд аймгийн ОБГ-аас гамшгийн багц сургалт, УЗН-ээс эмнэлгийн анхны тусламж, “ЦЭХС-т гарч буй аваар саатал ба тухайн үеийн системийн тогтвортой ажиллагаа” болон дотоодын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудыг зохион байгуулсны үр дүнд 2019, 2020 онд салбарын хэмжээнд осол, аваргүй ажиллажээ.

БҮЛЭГ 2. ТӨЛӨВЛӨСӨН ЗАРДЛЫГ ХЭТРҮҮЛЭН ЗАРЦУУЛЖ БАЙНА.

2.1. Салбарын орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн байна.

2.1.1. ААНБ-аас цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалга, тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого:

Салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, тоноглолоор ЦЭХ-ийг тасралтгүй, найдвартай дамжуулах үйл ажиллагааг хангаж ажилладаг байна. Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөхдөө өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэн судалж борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцож, дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тогтмол тарифаар төлөвлөжээ. Орлогын төлөвлөгөөг урьд онтой харьцуулахад 47.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №3
/сая төгрөгөөр/

Орлогын нэр	2018 оны гүйц	2019 он		2020 он		Өсөлт (+), бууралт (-)			
						2019 оны төл-өөс		2019 оны гүйц-ээс	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	тоо	хувь	тоо	хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	6,336.4	6,836.5	6,406.8	6,883.5	6,883.5	(47.1)	(0.7)	(476.7)	(7.4)

Төв компани үндсэн үйл ажиллагааны орлогыг 2019 онд салбарын ирүүлсэн саналаар, 2020 онд эхний хагас жилд сар бүр 550.3 сая, сүүлийн хагас жилд сар бүр 596.9 сая төгрөг байхаар тус тус бууруулж баталсан нь өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Дамжуулах ЦЭХ-ийг төлөвлөхдөө “ДСЦТС” ХК, Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн нэгдүгээр анги, экспорт, бусад ААНБ-аас ЦЭХ-ний хэрэглээний захиалга, тооцоо судалгаанд үндэслэн 2019 онд 520.0 сая.кВт.цаг, 2020 онд 563.2 сая.кВт.цагаар тус тус төлөвлөжээ. ЦЭХ-ийг 2020 онд өмнөх оноос 43.1 сая.кВт.цагаар илүү төлөвлөсөн нь 2019 онд Давхар, Бурхант дэд станцад цэвэр бохир усны системд холбогдсон, Бугант, Сүхбаатар, Шарын гол дэд станцад автомашины граж баригдсан, дэд станцуудын халаагуур, гэрэлтүүлгүүд нэмэгдсэн нь 2019-2020 оны төлөвлөгөөг нэмэгдүүлсэн нь үндэслэлтэй байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого:

Үндсэн бус үйл ажиллагааны орлогод нийт 8 төрлийн орлого хамаардаг бөгөөд цайны газрын болон түрээсийн орлогыг тогтмол дүнгээр төлөвлөж, төлбөрт ажил, үйлчилгээний орлогыг урьдчилан төлөвлөх боломжгүй тул урьд оны төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулан төлөвлөгөөгөө боловсруулжээ.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	2018 оны гүйц	2019 он		2020 он		Өсөлт (+), бууралт (-)			
		Төл	Гүйц	Төл	Гүйц	2019 оны төл-с		2019 оны гүйц-с	
						тоо	хувь	тоо	хувь
Хүүгийн орлого	1.0	1.1	1.5	0.5	0.5	0.63	57.3	1.01	68.2
Торгуулийн орлого	0.2	-	9.5	-	-	-	-	9.53	-
Төлбөрт ажил үйлчилгээний орлого	108.3	14.5	27.2	21.4	42.8	(6.9)	(47.5)	(15.6)	(57.6)
Цайны газрын орлого	34.2	40.8	37.0	44.3	41.8	(3.5)	(8.5)	(4.8)	(12.9)
Түрээсийн орлого	4.9	4.4	4.3	4.6	4.4	(0.2)	(4.3)	(0.1)	1.4
Хойшлогдсон хөрөнгийн орлого	-	330.4	314.1	372.3	372.3	(41.9)	(12.7)	(58.2)	18.5
Бусад орлого	31.4	2.0	0.3	0.9	3.4	1.1	55.0	(3.2)	(1,272.0)
Нийт	184.6	393.1	393.8	443.9	465.1	(50.8)	(12.9)	(50.1)	(12.7)

2019 оны орлогын төлөвлөгөөг 2018 оны гүйцэтгэлээс 208.5 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Бурхант дэд станцын шинэчлэл”-ийн ажил хийгдэж хөрөнгийн орлогыг НББББ-ийн 5.5.4²-т заасны дагуу бүртгэсэнтэй холбоотой. Энэ нь НББОУС-12, Сангийн Сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар баталсан аргачлалын дагуу заасантай нийцэж байна.

2.1.2. ЭХЗХ-ны тогтоолыг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар сар бүр тогтмол тарифаар орлогоо тооцож байна.

Гүйцэтгэх захирлын 2019 оны А/200 дугаар тушаалаар 2019 оны үндсэн үйл ажиллагааны сарын орлогыг 4 дүгээр улиралд 23.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 551.5 сая төгрөгөөр тодотгосноор нийт дамжуулалтын үйлчилгээний тариф 6,406.8 сая төгрөгт болж, гүйцэтгэл 93.7 хувьтай гарсан байна. Харин 2020 оны А/90 дугаар тушаалаар нийт 6,883.5 сая төгрөг болж, гүйцэтгэл 100 хувь биелжээ.

Техникийн үйлчилгээ, засвар үйлчилгээ, сэлгэн залгалт, хэмжилт, туршилт, ажил эхлэх зөвшөөрөл зэрэг төлбөртэй ажил, үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэхдээ ажил гүйцэтгэх гэрээ хийдэггүй бөгөөд нэхэмжлэхээр, бусад ажлыг ажил гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэж байна. 2019 онд 18.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажил, 2020 онд 44.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ажил хийж гүйцэтгэсэн боловч 2020 оны ажлыг “КОВИД-19” цар тахал гарч, гэрээ дүгнээгүйгээс 22.0 сая төгрөгийг үлдэгдлийг 2021 онд орлогоор бүртгэхээр хойшлуулсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-гээр өөрийн эзэмшилд байрлах цамхагт Мобиком, Юнителийн антен суурилуулж, бусад тоног төхөөрөмжүүдийг цамхгийн хажууд байрлах монтерүүдын өрөөнд байрлуулах зэрэг зөвшөөрөл олгон улсын төсөвт 40 хувь, байгууллага 60 хувиар тооцон гэрээнд заасны дагуу түрээсийн орлогыг бүртгэжээ.

² Засгийн газар буюу төрөөс: буцалтгүй тусламжаар үндсэн хөрөнгө олж авсан бол буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлого болгох ба тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэй, үл үндэслэлтэй сууриар хуваарилна.

Үүнээс үзэхэд үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 2019 онд 100.2 хувь, 2020 онд 104.8 хувьтай байна.

2.2. Төлөвлөсөн хөрөнгийг хэтрүүлэн зарцуулж байна.

2.2.1. Нийт зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Салбарын 2019, 2020 онд батлагдсан зардлыг өмнөх оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 2018 оноос 108.5 сая, 2019 оноос 509.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: 2019 онд зардлыг Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 0.3 сая төгрөгийг 0.5 сая төгрөгөөр, Компанийн хэмжээнд зохион байгуулах тэмцээнийг салбар дээр зохион байгуулахаар төлөвлөж 25.6 сая төгрөгөөр, гэрээт харуул болон орон нутагт ажиллах эксковатор, тракторын түрээсийн төлбөрт 46.5 сая, салбарын орон тоог 2019 онд 5, 2020 онд 2-оор нэмсэн, засвар үйлчилгээнд 18.6 сая, цалин хөлс, НДШ, ажилчдын нийгмийн зардал, шатахуун, сургалт, хөдөлмөр хамгаалал, урсгал засвар, мэргэжлийн үйлчилгээний зардлууд 3.2-86.8 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Тус салбарын 2019 онд нийт зардлыг төлөвлөлтөд тодотгол хийгээгүй бөгөөд 2020 онд батлагдсан төсвийг 861.4 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байтал гүйцэтгэлээр 333.5 сая төгрөгийн зардал хэтэрсэн нь 2020 оны зардал үндэслэлгүй төлөвлөсөн болохыг харуулж байна.

2.2.2. Салбарын төлөвлөсөн зардлыг бууруулж баталснаас нийт зардал 3.9-4.3 хувиар хэтэрсэн байна.

Үйл ажиллагааны бус зардал нь гэрээт болон цайны газар, ахмадын ажлууд багассантай холбоотойгоор 2019 онд 7.7 сая, 2020 онд 7.2 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Хүснэгт №5

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2019 он		Хэтрэлт, хэмнэлт	2020 он		Хэтрэлт, хэмнэлт
		Төл	Гүйц		Төл	Гүйц	
1	Үйл ажиллагааны зардал	5,929.1	6,154.9	225.8	6,371.4	6,688.9	317.50
2	Удирдлагын зардал	1,107.1	1,164.6	57.5	1,185.2	1,206.7	21.50
3	Санхүүгийн зардал	38.5	41.7	3.2	36.6	38.3	1.70
4	Үйл ажиллагааны бус зардал	90.4	82.7	(7.7)	81.4	74.2	(7.20)
Нийт дүн		7,165.1	7,443.9	278.8	7,674.6	8,008.1	333.5

Салбар нь 2019 онд 7,443.9 сая, 2020 онд 8,008.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2019 онд 278.8 сая, 2020 онд 333.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

2018 оноос Дархан дэд станцад 3 монтер, Захиргаа аж ахуйн албанд 1 жолооч, санхүү албанд 1 тооцооны нягтлан бодогч зэрэг 5 орон тоог нэмсэн, албан томилолтын журамд өөрчлөлт орж, 2 дахин нэмэгдсэн, Дархан Уул аймгийн засаг даргын 01-А/228 тоот захирамжийн дагуу газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 36-49 хувь нэмэгдсэн зэргээс шалтгаалан цалин, НДШ-ийн зардал 151.5 сая, албан томилолтын зардал 39.1 сая, хөдөлмөр хамгааллын зардал 27.7 сая, хангамжийн зардал 3.1 сая, үндсэн хөрөнгийн элэгдэл 72.7 сая, цахилгааны зардал

3.4 сая, тээврийн зардал 2.4 сая, урсгал засварын зардал 1.1 сая, төсөвт төлөх төлбөр 7.7 сая төгрөг, санхүүгийн зардал 3.2 сая тус тус өссөн нь нөлөөлжээ.

Удирдлагын зардал 2019 онд 57.5 сая, 2020 онд 21.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн нь цалин, НДШ, албан томилолт, тээвэр, урсгал засвар, сэлбэг хэрэгслийн зардлуудыг хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Дээрх зардлууд хэтрэхэд “ЦДҮС” ТӨХК-иас салбарын төсвийн төлөвлөлтийг үл харгалзан өөрсдийн дураар нэмж, хасаж байгаа нь зарим зардлыг хэмнэх, хэтрүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ. Тухайлбал: “ЦДҮС” ТӨХК 2019 оны 10 дугаар сард тодотгол хийсэн бөгөөд салбарын зөвхөн орлогын гүйцэтгэлд тодотгол хийж, зардлыг тодотгоогүйгээс дээрх зардлууд хэтрэхэд нөлөөлсөн байна.

Харин 2020 онд салбарын төлөвлөсөн зардлыг гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/200 дугаар тушаалаар “КОВИД-19” цар тахалтай холбоотойгоор 10.2 хувь буюу 861.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.

Тодотгол хийхдээ салбарын тооцоо судалгаанд үндэслээгүйгээс ажилчдын нийгмийн хамгааллын зардал 3.2 сая, тээврийн зардал 8.3 сая, харилцаа холбооны зардал 1.4 сая, албан томилолт 4.1 сая, сургалт 2.1 сая, хөдөлмөр хамгаалал 28.1 сая, төсөвт төлөх төлбөр 3.2 сая, төлбөрт ажил үйлчилгээний зардал 2.2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Түүнчлэн салбарын төлөвлөсөн нийгмийн хамгааллын 9.0 сая төгрөгийг гүйцэтгэх захирлын тушаалаар хасаж тодотгосон ч 2020 оны Б/573 тушаалаар 6.0 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн нь төлөвлөгдөөгүй зардал гарахад хүргэжээ.

Энэ нь компани болон салбарын харилцан уялдаа холбоогүй, төсвийн сахилга бат, хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

2.2.3. Ажилчдын нийгмийн зардалд 6.4 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гаргасан байна.

Батлагдсан зардлын дийлэнх буюу 60.6 хувийг цалин хөлс, НДШ, 13.8 хувийг ажилчдын нийгмийн зардал, 1.3 хувийг урсгал зардал эзэлж байна.

Удирдлагын зардал

Салбарын ерөнхий ба удирдлагын зардлыг бизнес төлөвлөгөөнд 2019 онд 1,107.1 сая төгрөгөөр төлөвлөж, 1,164.6 сая төгрөгийг зарцуулсан бол 2020 онд 1,185.2 сая төгрөгөөр төлөвлөж, 1,206.7 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 57.5 сая, 21.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь 2019 онд ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээний 3.1 дэх заалтыг үндэслэн ажиллагсдын үндсэн болон тариф цалинг 2019 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Гэтэл 2020 оны цалинг тодотгол хийхдээ тооцоо судалгаагүйгээр 2.9 сая төгрөгөөр хасаж, тодотгосноос хэтэрсэн байна.

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал салбарын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд үндсэн цалинг зөрүүтэй тусгаж, нэмэгдэл цалинг тодорхой тусгаж өгөөгүй байна. Мөн салбарын дарга, дээд газрын зөвшөөрөлгүйгээр 2019 онд өөртөө илүү цагийн зөвшөөрөл олгож, 0.1 сая, 2019-2020 онд 0.7 сая төгрөгийн албан томилолтын зардал авчээ.

Түүнчлэн 2019 оны 12 сард Говийн бүсийн салбарын дэд станцуудтай танилцах томилолтын зардалд 0.2 сая төгрөгийг 2 ажилтанд илүү олгосон байна.

Урсгал зардал: Урсгал засварын зардалд 2019 онд 76.9 сая, 2020 онд 89.7 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 2019 онд 1.0 сая төгрөгийг хэтрүүлсэн бол 2020 онд 1.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тус зардлыг 2020 онд хэмнэсэн харагдаж байгаа ч Баясгалант дэд станцын 35 кВ-ын I секцийн хүчдэлийн трансформаторт эвдрэл гарч, төлөвлөснөөс 10.2 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсанд тодотголоор нэмж баталсан байв.

Хүснэгт №6

Урсгал засварын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2019 он			2020 он		
	Төл	Гүйц	зөрүү	Төл	Гүйц	зөрүү
Урсгал засварын зардал	75.9	76.9	1.0	90.9	89.7	(1.2)

Салбарын 2019 оны 7 дугаар сард “Баясгалант” дэд станцын гэмтэлд нэмж 10.2 сая, 12 дугаар сарын сүүлээр “Дархан” дэд станцад гэмтэл гарч 9.7 сая төгрөгийг зардал гарч, бусад саруудын гүйцэтгэлээс өндөр байсан тул ажлын жилийн төлөвлөгөө, хүсэлт, шаардах хуудас, нярвын тайлан зэрэг анхан шатны баримтуудтай тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

Нийгмийн зардал: Салбарын ажилчдын нийгэм асуудлын зардал нь нийт зардлын 2019 онд 6.8 хувь, 2020 онд 5.3 хувийг тус тус эзэлж байна. Нийгэм хамгааллын зардлыг 2019 онд 16.3 сая төгрөгөөр хэмнэсэн бол 2020 онд 2.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Хүснэгт №7

Нийгмийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Зардлын нэр	2019 он			2020 он		
	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
Хоолны үнийн хөнгөлөлт	226.1	218.1	(8.0)	273.3	268.7	(4.6)
Унааны үнийн хөнгөлөлт	25.1	20.7	(4.4)	22.7	21.9	(0.8)
Түлшний үнийн хөнгөлөлт	13.9	13.6	(0.3)	13.9	13.9	-
Хөнгөлөлтийн НДШ	38.4	36.6	(1.8)	44.8	44.2	(0.6)
Шагнал	11.4	11.3	(0.1)	8.1	6.6	(1.5)
Тэтгэмж, буцалтгүй тусламж	122.4	115.1	(7.3)	35.7	39.8	4.1
Нийгэм соёлын арга хэмжээний зардал	30.1	29.6	(0.5)	5.5	5.5	-
Биеийн тамирын арга хэмжээ	8.2	14.6	6.4	0.7	0.7	-
Эмчилгээ, сувиллын зардал	0.6	0.3	(0.3)	0.1	0.2	0.1
Орон байрны нөхцөл сайжруулах зардал	9.0	9.0	-		6.0	6.0
Нийт дүн	485.2	468.9	(16.3)	404.8	407.5	2.7

Урлаг, спорт, тэмцээний зардлын талаар: 2019, 2020 онуудад урлаг, спортын арга хэмжээний зардалд аймгийн болон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдын томилолтын зардал, унааны зардал, оролцооны мөнгө, компаниас зохион байгуулж буй тэмцээн уралдаан зэрэгт нийт 8.2 сая төгрөг зарцуулсан байна. 2019 онд баталсан төлөвлөгөөнөөс 6.4 сая төгрөг хэтэрсэн нь 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн б/2228 тоот албан бичгээр Эрчим хүчний салбарын спортын их наадам болсонтой холбоотой байна.



БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.1.1. Гүйцэтгэх захирлын тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг 2019 онд 14.3 хувь, 2020 онд 34.6 хувиар тус тус бууруулан баталжээ.

“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг албадаас ирүүлсэн захиалгын үндсэн дээр нэгтгэн боловсруулж төлөвлөгөөний төслийг “ЦДҮС” ТӨХК-д хүргүүлэн, төлөвлөгөөг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, 2019 онд нийт 2,500.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 90, 2020 онд 1,731.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар тус тус баталсан байна.

Хүснэгт №8

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлын төсөл,
батлагдсан төлөвлөгөө

/сая төгрөгөөр/

№	Бараа, ажил үйлчилгээний төрөл	2019 он			2020 он		
		Төсөл	Батлагдсан төлөвлөгөө	Зөрүү	Төсөл	Батлагдсан төлөвлөгөө	Зөрүү
1	ТЗБАХ	1,911.7	1,911.7	-	1,177.6	1,177.6	-
2	Их засвар	519.3	519.3	-	494.0	494.0	-
3	Хөрөнгө оруулалтын ажил	484.5	69.7	(414.8)	975.5	59.5	(916.0)
Нийт дүн		2,915.5	2,500.7	(414.8)	2,647.1	1,731.1	(916.0)

Салбарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг 2019 онд 14.3 хувь, 2020 онд 34.6 хувиар тус тус бууруулан баталжээ.

Техник зохион байгуулалтын ажил болон их засварын ажлыг байгууллагын онцлогоос хамаарч “ЦДҮС” ТӨХК-ийн төв удирдлагуудтай хийгдэх ажлын төслийг зөвшилцөн боловсруулдаг тул төсөлд өөрчлөлт ороогүй байна. Харин багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тавилга зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг 2019 онд 85.6 хувиар, 2020 онд 93.9 хувиар тус тус бууруулан баталсан байна.

3.1.2. Худалдан авах үйл ажиллагааны хууль журмын хэрэгжилт хангалтгүй байна.

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар 2019 онд 258.1 сая төгрөгийн 23, 2020 онд 273.1 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг хийж, шалгарсан компанитай гэрээ байгуулах эрх олгожээ. Салбарын даргын тушаалаар тендерийг хуулийн дагуу явуулах үүрэг бүхий үнэлгээний хороог ажлын онцлог, салбарын чиглэл, АЗ сертификат бүхий иргэдээс сонгон 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дүрслэл №2

Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төрөл /сая төгрөгөөр/



Эрх олгосон нийт 42 төсөл, арга хэмжээний 391.1 сая төгрөгийн 15 ТАХ-г харьцуулалтын аргаар, 140.1 сая төгрөгийн 27 ТАХ-г шууд худалдан авалтын гэрээгээр

тус зохион байгуулж, нийт төсөвт өртгөөс 21.3 сая төгрөгийн хэмнэсэн байна.

Аудитаар тендер сонгон шалгаруулалтыг хууль, журамд нийцсэн эсэхийг шалгахад дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- “Хөтөл дэд станцын реле хамгаалалт”-ын засварын ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас болох www.tender.gov.mn сайтад нийтлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1³, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.4⁴ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Харьцуулалтын аргаар тендер шалгаруулахдаа өдөр тутмын сонинд мэдээлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1⁵, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.4⁶ дахь заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.
- www.tender.gov.mn-д 130.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 тендерийн үр дүнг мэдээлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1⁷, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.2.7⁸ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- “Орхон дэд станцын ажилтнуудын орон сууц”, “Хөтөл дэд станцын граж, агуулахын барилга засварлах”, “Контторын хуучин торон хашааг хэсэгчлэн солих, агуулахын дээвэр засварлах”, “Тоолуурын мэдээлэл боловсруулах программ хангамж” зэрэг тендерийн нээлтийн тэмдэглэлд зарим гишүүд, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд иргэний төлөөлөл гарын үсэг

³ “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”

⁴ “Захиалагч хуулийн 21.1-д заасны дагуу өдөр тутмын сонинд нийтлэх тендерийн урилгад цахим системд нийтэлсэн огноо, бүртгэлийн дугаарыг заавал дурдана”

⁵ “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”

⁶ “Захиалагч хуулийн 21.1-д заасны дагуу өдөр тутмын сонинд нийтлэх тендерийн урилгад цахим системд нийтэлсэн огноо, бүртгэлийн дугаарыг заавал дурдана”

⁷ “Үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх”

⁸ “Үнэлгээний хорооны хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг ил болгох”

зураагүй, хурлын тэмдэглэл байхгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.7⁹, 47.8¹⁰ дахь заалтуудтай тус тус нийцээгүй.

- “Сүхбаатар дэд станцын 35 кВ-ын вакум таслуур” тендерийн үнэлгээний хорооны хурал нь 2019 оны 11 дугаар сарын 01-нд хуралдаж, үнэлгээний хорооны дүгнэлтийг хүргүүлэхээр шийдвэрлэсэн ч Үнэлгээний хорооны дүгнэлт 7 хоногийн өмнө гаргасан.
- “Баясгалант дэд станцын ОПУ-ын дээврийн засвар”-ын ажлын төсөвт өртгийг хувааж, засварын ажилд 6.0 сая, засварын материалд 8.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5¹¹ дахь заалттай нийцэхгүй байна.
- Үнэлгээний хорооны гишүүд тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахдаа харилцан адилгүй шалгуур үзүүлэлт тусгажээ. Тухайлбал ажилчдын ур чадвар, техник тоног төхөөрөмжийн жагсаалтыг зарим ажилд шаардсан бол ижил төрлийн ажилд шаардаагүй нь тендер шалгаруулалтын үнэлгээ, ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Тендерийн шалгуур үзүүлэлтэд заасан баримт материалууд ажлын баримтад байхгүй байна. Үүнд:

- “Контторын гадна эко авто зогсоол хийх, авто зам сайжруулах ажил”-ын сонгон шалгаруулалтад тэнцсэн “Чуулгант” ХХК-ний ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлага, 2018 оны санхүүгийн тайлан,
- “Бурхант, Давхар дэд станцуудын цэвэр бохир усны шугам”-ын ажлын сонгон шалгаруулалтад тэнцсэн “Ноён өндөр констракшн” ХХК-ны татварын тодорхойлолт, засварын ажилд хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, мэргэжилтэн ажилтнуудын ур чадварын тодорхойлолт, 2018 оны санхүүгийн тайлан,
- “Контторын хуучин торон хашааг хэсэгчлэн солих, агуулахын дээвэр” засварлах тендерт шалгарсан “ГЭЭТ” ХХК-ний 2019 оны санхүүгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байв.

Аудитын явцад ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1¹² дэх заалтыг мөрдөж ажиллаагүйгээс “Баясгалант дэд станцын 35 кВ-ын ХТ1-ын В,С фазуудыг солих”, “Хөтөл дэд станцын реле хамгаалалт” зэрэг ажлын тендер шалгаруулалтын хавтаст хэргийг бүрдүүлээгүй байсныг тайлагналын үе шатанд архивын нэгж болгон баримтжуулав.

⁹ “Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.

¹⁰ “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүний үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсэг зурна”

¹¹ “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үндэс багтаах, эсвэл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”

¹² “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”

3.1.3. Худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтын эрхийг 2020 оны 10 дугаар сард олгосноос 2 ажил хийгдэж амжаагүй, 89.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар нь 2019 онд 23 ТАХ-нд 258.1 сая төгрөгөөр зарцуулж 100 хувийн гүйцэтгэлтэй 15.0 сая, 2020 онд 19 ТАХ-нд 266.8 сая төгрөг зарцуулж, 89.5 хувийн гүйцэтгэлтэй 6.3 сая төгрөг тус тус хэмнэжээ.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/1587 дугаар албан бичгээр “Тоолуурын мэдээллийн санд холбох 15 ширхэг электрон тоолуурыг нийлүүлэх”, “Баясгалант дэд станцын 35кВ-ын ХТ-ын В, С фазуудыг солих” зэрэг ажлын сонгон шалгаруулалт хийх эрхийг салбарын даргад олгосноос энэ ажлууд тайлант хугацаанд хийгдээгүй байна.

“КОВИД-19” цар тахлын улмаас тендер шалгаруулалтын ажлын гүйцэтгэлийг гэрээ, гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлантай, техник, тоног төхөөрөмж, их засварын ажлын бүртгэл тайлагналыг салбарын даргын тушаал, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад зөрчил илрээгүй.

3.2. Өмч хамгаалах зөвлөлийн журмыг шинэчлэн боловсруулаагүйгээс хөрөнгөд тавих зарим хяналтын ажил орхигдож байна.

3.2.1. Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө эргэлтийн хөрөнгийн 17.8 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд 4,145.95 сая төгрөгөөр нэмэгдсэн нь компанийн хөрөнгө оруулалтаар 1,905.6 сая, их засвараар 660.4 сая, ТЗБАХ-ээр 1,579.9 сая, 2020 онд 1,980.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь компанийн хөрөнгө оруулалтаар 71.1 сая, их засварын ажлаар 483.3 сая, ТЗБАХ-ээр хийгдсэн ажлын капиталжуулалтаар 1,255.9 сая, балансаас балансад 169.9 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай холбоотой.

Үүнээс 2020 онд 327.7 сая төгрөгийн барилга байгууламж, 1,378.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 181.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 19.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 54.4 сая төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл, 18.1 сая төгрөгийн биет бус хөрөнгө нэмэгджээ.

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны А/206 тоот тушаалаар 48.0, 2020 оны А/139 тоо тушаалаар 2.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан байна.

Салбарын 2019-2020 онд санхүүгийн тайланд бүртгэлтэй бараа материалын хөдөлгөөнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №9

Агуулахад байгаа эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөн

/сая төгрөгөөр/

Он	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Эцсийн үлдэгдэл
2019 он	193.7	765.5	805.6	153.6
2020 он	153.6	839.8	849.4	144.0

2020 оны жилийн эцсээр агуулахад байгаа эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг насжилтаар нь судалж үзэхэд дараах байдалтай байна.

Бараа материалын үлдэгдлийн насжилт /сая төгрөгөөр/



Үүнээс харахад агуулахад байгаа эргэлтийн хөрөнгийн 17.8 %-ийг 2011 оноос өмнөх хөрөнгө эзэлж байгаа бөгөөд ашиглагдах боломжгүй хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө хадгалагдаж байна.

Мөн ажилчин албан хаагчдын гар дээрх эргэлтийн хөрөнгө 2019 оны эхэнд 222.2 сая төгрөгийн хөрөнгө байснаас 29.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, гүйцэтгэх захирлын 2019 оны А/209 тоот тушаалаар 3.8 сая төгрөгийн хөрөнгө актлагджээ. Харин 2020 онд 12.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 9.4 сая сая төгрөгийн хөрөнгийг гүйцэтгэх захирлын 2020 оны А/142 тоот тушаалаар акталж, үлдэгдэл 250.9 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл байна. НБББББ-т заасны дагуу эдгээр хөрөнгийг балансаас гадуур бүртгэж, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилладаг байна.

Тооллогын комисс 2020 оны жилийн эцсийн байдлаар агуулахад байгаа ашиглагдах боломжгүй 36 нэрийн 77.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 52 нэр төрлийн 14.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, салбарын ажилтнуудад карталсан 158 нэр төрлийн 11.4 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлахаар салбарын даргад санал хүргүүлжээ.

3.2.2. Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулаагүйгээс зарим хяналтын ажил орхигдож байна.

Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг салбарын захирлын 2017 оны А/28 дугаар тушаалаар шинэчлэн Зөвлөлийн даргаар ерөнхий инженер, нарийн бичгийн даргаар тооцооны нягтлан бодогч, гишүүдэд хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн инженер, санхүү эдийн засгийн албаны дарга бөгөөд ахлан нягтлан бодогч, засварын албаны дарга, ашиглалт шуурхай үйлчилгээний албаны дарга, реле хамгаалалт автоматик, хэмжүүр, туршилтын албаны дарга, ашиглалтын инженер, автын механик зэрэг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ.

Тус салбар нь өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-д нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлогт уялдуулан шинэчлэн боловсруулаагүй, журмын 3.1, 3.10, 3.12, 3.13-т заасан өмч хамгаалах зөвлөлийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ашиглалт, чанар байдалд тавих хяналтыг сайжруулах ажлууд орхигдож байна.

Ажлын тайлангаас үзэхэд үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогын үр дүнг хэлэлцэж, цаашид дахин ашиглах боломжгүй болсон хөрөнгүүдийг данснаас хасах, акталсан хөрөнгийг дахин ашиглах, зарж борлуулах талаар шийдвэр гаргаснаас өөр ажил хийгээгүй байна.

Аудитын талбарын ажлыг “КОВИД-19” цар тахлын нөхцөл байдлын улмаас салбарын санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны үр дүнг асуулга, тодруулга, ирүүлсэн баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.



ДҮГНЭЛТ:

Аудитаар нийт 592.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгаж таслан зогсоох 1 албан шаардлага, 592.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Салбарын 2019-2020 оны дэвшүүлсэн зорилтод хүрэх ажлын төлөвлөгөө боловсруулаагүйгээс 4 зорилт, тодорхой шалтгааны улмаас 5 ажил бүрэн хэрэгжээгүй байна.
- Зарим инженерийн эзэмшсэн мэргэжил ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур хангахгүй байна.
- Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулаагүйгээс үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт давхардаж байна.
- Хяналт шалгалт хийсэн ажлын баримт материалыг архивын нэгж болгож, баримтжуулаагүй байна.
- ААНБ-аас ЦЭХ-ний хэрэглээний захиалга, тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөсөн бөгөөд ЭХЗХ-ны тогтоолыг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар сар бүр тогтмол тарифаар орлогоо тооцож байна.
- Нийт зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөснөөс зардал 3.9-4.3 хувиар хэтэрч, ажилчдын нийгмийн зардалд төлөвлөгдөөгүй 6.4 сая төгрөг зарцуулсан байна.
- Салбарт эрх шилжсэн худалдан авах ажиллагаа 2019 онд 100 хувь, 2020 онд 89.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд холбогдох хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.
- Өмч хамгаалах зөвлөл үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулаагүйгээс хөрөнгөд тавих зарим хяналт хийгдэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын дарга Ж.Мөнхжаргалд:

1. Салбарын зорилт, ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа харилцан уялдаатай, биелэгдэхүйц байхаас гадна цаг хугацаа, боловсон хүчин, техник тоног төхөөрөмжийн нөөц, санхүүгийн эх үүсвэр, судалгаанд тулгуурлах;
2. Дотоод хяналт, шалгалтын үр нөлөөг сайжруулж, илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулж, ажлын баримт материалыг архивын нэгж болгох;
3. Зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах, спортын тэмцээн уралдаан, баяр ёслол зэрэг арга хэмжээнд олгож байгаа зардлыг цаашид бууруулах, төлөвлөгдөөгүй зардал гаргахгүй байх;
4. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах;
5. ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу тендерийн өгөгдлийн хүснэгт, тендерийн материалын бүрдүүлбэрт анхаарч, баримт бичгийн хяналтыг сайжруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны дотор багтаан Дархан-Уул аймаг дахь Төрийн аудит газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР